



# COVID-19-н шинжилгээ

## Би хэзээ COVID-19-н шинжилгээ хийлгэх ёстой вэ?

- Танд COVID-19-н шинж тэмдгүүд илэрсэн байна.
- Та [хүндээр өвчлөх өндөр эрсдэлтэй](#) бөгөөд COVID-19-н халдвартай хэн нэгэнтэй саяхан хавьтал болсон.
- Та ахуйн хавьталд орсон эсвэл COVID-19-н халдвартай хэн нэгэнтэй өндөр эсвэл дунд зэргийн эрсдэл бүхий хавьтал болсон.



## Ямар хүмүүс хүнд өвчлөх өндөр эрсдэлтэй вэ?

- 60 болон түүнээс дээш насны иргэд
- Жирэмсэн эмэгтэйчүүд
- Уугуул, Торрес Стрэйт Арлын болон Номхон Далайн Арлын хүмүүс (35 болон түүнээс дээш настай)
- Таргалалт, чихрийн шижин, зүрх судасны ноцтой эмгэг, архаг уушигны эмгэг (*сүүлийн 12 сард эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүнд зэргийн астма орно*), архаг бөгөөд хүнд элэг, бөөрний эмгэг мөн идэвхитэй халдвартай эсвэл дархлаа суларсан хүмүүс
- Хөдөлмөрийн бэрхшээлтэй хүмүүс ялангуяа уушиг, зүрх болон дархлалын системд нөлөө бүхий хөдөлмөрийн бэрхшээлтэй хүмүүс
- Өндөр настны болон хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийн асрах газрын оршин суугчид
- Дархлаажуулалтанд хамрагдаагүй 18 болон түүнээс дээш настай хүмүүс

## COVID-19-н ямар шинжилгээг хийлгэх ёстой вэ?


COVID-19-н халдвар авсан эсэхээ шалгах боломжтой **хоёр өөр төрлийн шинжилгээнүүд** байдаг. Үүнд өөрөө хийх боломжтой **эсрэг бие илрүүлэгч түргэвчилсэн шинжилгээ** (RAT) болон клиник, эмнэлгүүдэд хийлгэх **PCR** (хамар болон хоолойн арчдас) **шинжилгээ** орно.

- **Хэрвээ та хүнд өвчлөх өндөр эрсдэлтэй бол PCR шинжилгээг** хийлгэх ёстой. Хэрвээ та PCR шинжилгээнийхээ хариуг хурдан хугацаанд авах боломжгүй бол PCR шинжилгээний хариу гарахыг хүлээх хугацаандаа эсрэг бие илрүүлэгч түргэвчилсэн шинжилгээ (танд байгаа бол) хийж болно.
- Хэрвээ та хүндээр өвчлөх эрсдэлтэй **биш** бөгөөд эмч PCR шинжилгээ хийлгэхийг шаардаагүй бол эсрэг бие илрүүлэгч түргэвчилсэн шинжилгээг хийж болно.



## Хэрвээ би COVID-19-н шинжилгээгээр эерэг хариу авсан бол юу хийх вэ?

- Хэрвээ танд шинж тэмдгүүд илрээгүй мөртлөө **PCR шинжилгээгээр эерэг** хариу авсан бол та COVID-19-н халдвар авсан гэсэн үг. Та [COVID-19-н шинжилгээгээр эерэг хариу авах](#), [COVID-19-н халдварт гэртээ аюулгүй арга хэмжээ авах](#) тухай зөвлөмжийг мөрдөх ёстой.
- Хэрвээ та эсрэг бие илрүүлэгч түргэвчилсэн шинжилгээгээр эерэг хариу авсан бол [хариураа Service NSW-д бүртгүүлэн](#), [COVID-19-н шинжилгээгээр эерэг хариу авах болон COVID-19-н халдварт гэртээ аюулгүй арга хэмжээ авах](#) тухай зөвлөмжийг мөрдөх ёстой.



Хэрвээ танд ямар нэгэн эрүүл мэндийн асуудал байгаа бөгөөд орчуулгын тусламж хэрэгтэй бол **TIS**-ийн **131 450** дугаарт залган **1800 022 222** гэсэн дугаараар Health Direct-тэй холбож өгөхийг хүсээрэй.